



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 1118

Дадал сум

**Эрсдэлийн сангаас зардал гаргах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/346 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 08:00 цагаас 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд ажлын тусгай горимд шилжүүлж, гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл бэлэн байдлын штабын бүрэлдэхүүний хоолны 100,000 (Нэг зуун мянга) төгрөг, аймгийн Хэрлэн суманд 2025 оны 06 дугаар сарын 24-нөөс 06 дугаар сарын 26-ны өдрүүдэд зохион байгуулагдах сургуулийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор асар ор хүргэх, сумдын Засаг дарга нар уг сургуулилалтад хамрагдаж очиж ирэх шатахууны зардалд 989,240 (Есөн зуун наян есөн мянга хоёр зуу) төгрөг, шуурхай штабын сургалтын зардалд 1,084,000 (Нэг сая наян дөрвөн мянга) төгрөг, аймгийн Засаг даргын А/206 дугаар захирамжаар сумдад хуваарилсан малын тэжээл татаж авах шатахууны зардалд 489,600 (Дөрвөн зуун наян есөн мянга зургаан зуу) төгрөгийн зардлыг тус тус гаргасугай.

2. Нийт 2,662,840 (Хоёр сая зургаан зуун жаран хоёр мянга найман зуун дөх) төгрөгийн зардлыг эрсдлийн сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

011000359